



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 341

Улаанбаатар х

Хорооны 2012 оны 82 дугаар тогтоол болон 60, 206 дугаар тогтоолуудаар батлагдсан журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн “Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний жагсаалт” батлах тухай 82 дугаар тогтоолын 1 дэх заалтын “3/ Цахим төлбөр тооцооны төлөөлөгчөөр ажиллах үйлчилгээ” гэсний дараа “4/ Даатгалын төлөөлөгчийн ажил, үйлчилгээ” гэж нэмсүгэй.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 206 дугаар тогтоолоор батлагдсан "Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай дараах 1.5.7 дахь заалт нэмсүгэй:

1/ 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 7 дахь заалт:

“1.5.7. “даатгалын төлөөлөгч” гэж даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий даатгагчийн томилсон буюу эрх олгосон этгээдийг”.

3. Мөн журмын 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах 2.5 дахь хэсэг нэмсүгэй:

1/ 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“2.5 Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа /ажил, үйлчилгээ/ эрхлэхтэй холбогдсон харилцааг Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-ын дагуу зохицуулна.

4. Мөн журмын 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах 3.4 дэх хэсэг нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"3.4 Даатгалын төлөөлөгчийн ажил, үйлчилгээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-д заасан шаардлагыг хангасан байна."

5. Мөн журмын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсгийн "...Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, " гэсний дараа " ... Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, " гэж нэмсүгэй.

6. Мөн журмын 2 дугаар зүйлийн 1.2 хэсгийн 2.1.2 дахь заалтын "...дээрх журмын ..." гэснийг "...Хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан "Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам"-ын ..." гэж өөрчилсүгэй.

7. Мөн журмын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн 2.1.1 дэх заалтыг хүчингүй болгосугай.

6. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 60 дугаар тогтоолоор батлагдсан "Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг бүхэлд нь хүчингүй болгосугай.

7. Журмууд болон тогтоолд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулж, олон нийтэд мэдээлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН